



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот


Баянзүрх дүүрэгт эргүүлээр ажиллах
байгууллагуудын үйл ажиллагаанд
хяналт тавьж ажиллах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 10 дугаар зарлиг", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30, 39, 62, 63 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/166, А/168, А/191 дүгээр захирамж, Нийслэлийн Онцгой комиссын даргын 2020 оны 1, 2 дугаар тушаал, Нийслэлийн онцгой комиссын 2, 3, 4 дүгээр хурлын шийдвэр, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Онцгой комиссын Орлогч даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн баталсан хуваарийн дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Баянзүрх дүүрэгт "Иргэд, олон нийтийг шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх нэгдсэн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, эргүүл жижүүрээр ажиллах байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах"-аар болсонтой холбогдуулан 2020 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 02 дугаар сарын 26-ны өдрүүдэд Баянзүрх дүүрэгт эргүүлээр ажиллах байгууллагуудад хяналт тавих ажилтнуудын хуваарь, чиг үүргийг хавсралт ёсоор баталсугай.

2.Нийслэлийн онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу иргэд олон нийтийг шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч, Даваа-Баасан гарагт 10:20:00 цаг, Бямба, Ням гарагт 11:00-19:00 цагийн хооронд эргүүлээр ажиллах нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд чиглэлийн дагуу хяналт тавьж, мэдээллээр шуурхай хангаж, ажлаа тайлагнаж, сурталчилж ажиллахыг тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

3.Тушаалыг албан тушаалтнуудад танилцуулж, ажлыг тухай бүр олон нийтэд сурталчилж, мэдээлж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, явц үр дүнг танилцуулж ажиллахыг Дотоод хяналтын хэлтэс /Ц.Рэгзэдмаа/-т тус тус даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Д.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2020 оны 02 сарын 20
 2020 тушаалын хавсралт



БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ ШИНЭ КОРОНАВИРУСИЙН
 ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
 ЭРГҮҮЛЭЭР АЖИЛЛАЖ БУЙ БАЙГУУЛЛАГУУДАД
 ХЯНАЛТ ТАВИХ АЖИЛТНУУДЫН ХУВААРЬ, ЧИГ ҮҮРЭГ
 /2020.02.22-2020.02.26/

№	Гараг	Албан хаагчийн нэр	Албан тушаал	Жижүүрт гарах		Эргүүлээр ажиллах байгууллагуудын жагсаалт
				Сар өдөр	Цаг	
1	Бямба	М.Энхтуяа	Тооцооны нягтлан бодогч	II/22	11:00 19:00	1. Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар,
2		Я. Бадмаа	Хоол үйлдвэрлэл үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн			
3	Ням	Л.Булган	Дизайн, зураг төсөл хариуцсан мэргэжилтэн	II/23	11:00 19:00	2. Улаанбаатар хотын музей,
4		С.Эрдэнэболд	Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн			3. Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар,
5	Даваа	Н.Мөнхшүр	Иргэдийн өргөдөл, эрэлт хүсэлт, үйлчилгээ хариуцсан ажилтан	II/24	09:00 20:00	3. Хот байгуулалт, хөгжлийн газар,
6		Н.Мөнхжин	Иргэдийн өргөдөл, эрэлт хүсэлт, үйлчилгээ хариуцсан ажилтан			4. Нийтийн тээврийн үйлчилгээний газар,
7	Мягмар	Н.Мөнхгаамаа	Иргэдийн өргөдөл, эрэлт хүсэлт, үйлчилгээ хариуцсан ажилтан	II/25	09:00 20:00	5. УСУГ 6. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ,
8		Б.Халиун	Тооцооны нягтлан бодогч			7. Нийслэлийн Авто замын хөгжлийн газар,
9	Лхагва	Г.Индаръяа	Шуурхай ажил хариуцсан ахлах мэргэжилтэн	II/26	09:00 20:00	8. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ,
10		Б.Номингэрэл	Дотоод хяналтын ахлах мэргэжилтэн			9. Нийгмийн хамгаалалын тусгай төв, 10. Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ, 11. Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ.

АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ:

1. Нийслэлийн Онцгой комиссын орлогч даргын 2020.02.17-ны өдрийн баталсан "Шинэ төрлийн коронавирусын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч эргүүлээр ажиллах хуваарь", Баянзүрх дүүргийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын 2020.02.19-ний өдрийн баталсан "Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх эргүүлээр ажиллах хуваарь"-т орсон нийслэлийн нутгийн захиргааны 12 байгууллага, Дүүргийн дэргэдэх байгууллагуудын "Иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч эргүүлээр ажиллах хуваарь", хэрэгжилтэд хяналт тавих,
2. Тухайн өдөр хуваарийн дагуу эргүүлээр ажиллаж буй байгууллагуудтай холбогдож, мэдээ мэдээлэл авч, хяналт тавьж ажиллана.
3. Байгууллага тус бүрийн зурагт тэмдэглэсэн маршрутаар болон иргэд олноор цуглардаг аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээний газар / зах, худалдааны төв, дэлгүүр, баар, караоке/-д хяналт тавина.
4. Эргүүлийн хяналт тавих хугацаанд аливаа зөрчил, шаардлагатай зүйлсийг зураг болон дүрсжүүлж авсан байна.
5. Хариуцлагатай жижүүр нь ажилласан тухай илтгэх хуудсыг бичиж, мэдээллийг албаны фейсбүүк хуудсаар мэдээлж, ажилласан цагаа баталгаажуулна.